

НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР

СТАТИСТИКИЙН ТАНИЛЦУУЛГА

Нийслэлийн эдийн засаг,
нийгмийн байдал



2014 оны
2-р сар

АГУУЛГА

	Хуудасны дугаар
1. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт	2
2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	3
3. Хэрэглээний үнэ	4
Хэрэглээний үнийн индекс	
Мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэ	
Түлш, шатахууны үнэ	
Төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш	
Хэрэглээний барааны үнийн зэрэгцүүлэлт	
Барилгын материалын үнэ	
Аж үйлдвэр	12
Хүн амын ажил эрхлэлт	15
Нийслэлийн төсөв	16
Нийгмийн даатгалын үйлчилгээ	20
Эрүүл мэндийн үйлчилгээ	22
Амьдарч буй орчин	24
Цаг агаарын байдал	
Гадаргын усны бохирдол	
Агаарын бохирдол	
Хотын нийтийн аж ахуйн үйлчилгээ	27
Хотын аюулгүй байдал	28
Гамшигт үзэгдэл	
Малын зүй бус хорогдол	
Гэмт хэргийн байдал	

Хүснэгт 1. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн 2 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2010 он	2011он	2012 он	2013 он	2014 он
Суурин хүн ам, оны эцэст	мянган хүн	1112.6 ↑3.7	1166.8 ↑4.9	1212.9 ↑4.0	1233.0↑1.7	1273.5↑3.3
Шинээр төрсөн хүүхэд	тоо	5006 ↑14.5	4698 ↓6.2	5406 ↑15.1	6079↑12.4	6326↑4.1
Ажилгүйчүүд, сарын эцэст	мянган хүн	6.8 ↓9.3	8.6 ↑26.5	29.3 ↑240.7	13.2↓54.9	11.8↓10.6
үүнээс: эмэгтэй	мянган хүн	3.4 ↓15	4.4 ↑29.4	12 ↑172.7	6.7↓44.2	6.1↓9.0
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	2108 ↓15.6	2460 ↑16.7	3643 ↑48.1	2827↓22.4	2470↓12.6
Бүртгэсэн гэмт хэрэг	тоо	1766 ↓4.5	1871 ↑5.9	2212 ↑18.2	2587↑17.0	2673↑3.3
Хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлт	хувь	3.9 ↑4.0	0.3 ↓3.6	2.6 ↑2.3	1.1↓1.5	1.0↓0.1
Валютын зах зээлийн ханш, сарын эцэст	1US\$ =₮	1448 ↓1.5	1254.5 ↓13.4	1340.2 ↑6.8	1402↑4.6	1752↑25.0
Нийслэлийн төсвийн орлого	тэрбум төгрөг	16.3 ↑17.5	25.1 ↑54.0	46.1 ↑83.6	102.4↑1.2д	116.4↑13.7
Нийслэлийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	8.9 ↑107.7	10.2 ↑14.6	9.6 ↓5.8	55.0↑4.7д	72.1↑31.1

Тайлбар: өмнөх онтой харьцуулсан өөрчлөлтийн хувь
 ↑, ↓ эерэг
 ↑, ↓ сөрөг
 = тогтвортой

Хүснэгт 2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд, дүүргээр

	Хэмжих нэгж	2013 оны 2 сарын байдлаар					2014 оны 2 сарын байдлаар				
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	262	Баянгол	6558	Налайх	48	271	Баянгол	6816	Налайх	49
			Чингэлтэй	1731	Багануур	45		Чингэлтэй	1754	Багануур	45
			Сүхбаатар	637	Багахангай	26		Сүхбаатар	643	Багахангай	27
Ажилгүйчүүд Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох	0\000**	163	Багахангай	735	Хан-Уул	132	141	Налайх	376	Баянзүрх	129
			Налайх	710	Сонгинохайрхан	128		Багахангай	288	Хан-Уул	128
			Сүхбаатар	293	Баянзүрх	91		Сүхбаатар	153	Сонгинохайрхан	128
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	14	Сүхбаатар	21	Чингэлтэй	10	16	Багахангай	91	Баянгол	11
			Багануур	20	Налайх	6		Налайх	29	Сонгинохайрхан	11
			Хан-Уул	15	Багахангай	-		Хан-Уул	23	Сүхбаатар	10
10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	23	Налайх	45	Хан-Уул	15	20	Баянзүрх	20	Сонгинохайрхан	13
			Багануур	43	Багахангай	13		Багануур	20	Баянгол	12
			Сонгинохайрхан	21	Баянгол	12		Чингэлтэй	19	Багахангай	5
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	мян.төг	275	Багахангай	151	Багануур	120	162	Сүхбаатар	168	Баянгол	126
			Баянзүрх	132	Хан-Уул	117		Хан-Уул	161	Багахангай	125
			Сүхбаатар	129	Налайх	115		Чингэлтэй	154	Налайх	121
18-аас дээш насны 10000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	30	Сүхбаатар	50	Хан-Уул	21	31	Сүхбаатар	44	Сонгинохайрхан	25
			Чингэлтэй	38	Налайх	20		Баянгол	33	Налайх	23
			Баянзүрх	30	Багахангай	20		Чингэлтэй	33	Багахангай	8

Тайлбар: * - промиль


** - продициль



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2014 оны 2-р сарын хэрэглээний үнийн индекс 2013 оны мөн үетэй харьцуулахад 12.0 хувь, 2013 оны жилийн эцэстэй харьцуулахад 2.8 хувь, өмнөх 1-р сартай харьцуулахад 1.0 хувиар тус тус өссөн байна.

Зураг 1. Хэрэглээний үнийн индекс, өмнөх сартай харьцуулснаар



Хүнсний бараа, ундаа, усны бүлгийн барааны үнэ 2.6 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийнх 0.5 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 0.6 хувь, гэр ахуйн барааных 0.6 хувь, тээврийн үйлчилгээнийх 0.7 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ 0.6 хувиар тус тус нэмэгдснээр хэрэглээний үнэ өмнөх сараас өсчээ.

Хүснэгт 3. Хэрэглээний үнийн индекс, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2014-02</u> 2013-02	<u>2014-02</u> 2013-12	<u>2014-02</u> 2014-01
Ерөнхий индекс	112.0	102.8	101.0
Хүнсний бараа, ундаа, ус	110.1	106.4	102.6
Согтууруулах ундаа, тамхи	112.5	100.8	100.5
Хувцас, бөс бараа, гутал	114.7	101.2	100.6
Орон сууц, ус, цахилгаан, түлш	111.9	100.0	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	121.7	100.9	100.6
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	121.6	100.0	100.0
Тээвэр	104.6	104.5	100.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	99.8	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	98.0	100.1	100.0
Боловсролын үйлчилгээ	128.4	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	113.8	100.6	100.6
Бусад бараа, үйлчилгээ	122.7	101.4	100.0

2014 оны 2-р сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгосон 329 нэрийн бараа, үйлчилгээний 20.7 хувийнх нь үнэ өсч, 9.7 хувийнх нь үнэ буурч, 69.6 хувийн бараа үйлчилгээний үнэ тогтвортой байлаа.


Хүснэгт 4. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн жилийн индекст нөлөөлсөн бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, ундаа, ус	2.6	Энэ бүлгийн өсөлтөд талх, гурил, будаа 0.4 хувь, мах, махан бүтээгдэхүүн 4.9 хувь, загас, далайн бүтээгдэхүүн 0.7 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн 2.2 хувь, төрөл бүрийн өөх, тос 0.7 хувь, жимс, жимсгэнэ 2.0 хувь, төмс, хүнсний ногоо 0.1 хувь, сахар, жимсний чанамал, чихэр, шоколад 0.1 хувь, бүх төрлийн цай, кофе, какао 3.2 хувь, рашаан ус, ундаа 1.2 хувиар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.
Согтууруулах ундаа, тамхи	0.5	Согтууруулах ундаа, тамхины бүлгийн өсөлтөд дарсны үнэ 0.4 хувь, шар айраг 3.0 хувь, тамхи 1.4 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
Хувцас, бөс бараа, гутал	0.6	Энэ бүлгийн үнэ өсөхөд хөвөн, бөс бараа 1.4 хувиар, эмэгтэй бэлэн хувцас 0.7 хувиар, хүүхдийн бэлэн хувцас 2.8 хувиар, бүх төрлийн гутал 0.9 хувиар өссөнтэй холбоотой байлаа.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	0.6	Гэр ахуйн тавилга, барааны өсөлтөд цахилгаан бараа 2.5 хувь, гэр ахуйн бараа 0.4 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.
Тээвэр	0.7	Тээврийн бүлгийн үнийн өсөлтөд хувийн тээврийн хэрэгслийн шатах, тослох материал 1.1 хувь, авто замын зорчигч тээврийн үйлчилгээ 1.4 хувиар өсөлт нөлөөлөв.
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	0.6	Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны бүлгийн үнийн өсөлтөд ресторан, кафе, бусад зоогийн газрын үйлчилгээ 1.8 хувиар өсч нөлөөлөв.

Зураг 2. Нэг кг дээд гурилын дундаж үнэ, 2009-2014 оны 2-р сард, төгрөг




Зураг 3. Нэг кг будааны дундаж үнэ, 2009-2014 оны 2-р сард, төгрөг




Сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ бүлгийн дүнгээр өмнөх сараас 2.2 хувиар, хүнсний ногооны үнэ бүлгийн дүнгээр 0.1 хувиар тус тус өссөн байлаа.

Зураг 4. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, 2009-2014 оны 2-р сард




Зураг 5. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, 2009-2014 оны 2-р сард



Зураг 6. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, 2009-2014 оны 2-р сард



Зураг 7. Нэг ширхэг өндөгний дундаж үнэ, 2009-2014 оны 2-р сард



2014 оны 2-р сард хүнсний зах, дэлгүүрт мах, махан бүтээгдэхүүний жижиглэн худалдах үнэ өмнөх сараас бүлгийн дүнгээр 4.9 хувиар өсч, үүнд хонь, үхэр, адуу, ямааны мах 0.1-8.0 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.


2014 оны 2-р сарын 28-ны өдрийн үнийн ажиглалтаар “Хүчит шонхор” зах дээр нэг кг тэмээний мах 6200 төгрөг, “Далай ээж” зах дээр гахайн мах 9500 төгрөг, тахианы мах 6500 төгрөгийн ханштай байв. Багануур, Эмээлт захын дундаж үнээр нас гүйцсэн адуу 800.0 мянган төгрөг, үхэр 1.1 сая төгрөг, эр хонь 190.0 мянган төгрөг, эм хонь 170.0 мянган төгрөг, ямаа 65.0-120.0 мянган төгрөгийн ханштай байв.

Улаанбаатар хотын түүхий эдийн захуудад ямааны ноолуур 67000 төгрөг, тэмээний шир 20500 төгрөг, адууны шир 30500 төгрөг, үхрийн шир 1.8-2.3 метр урттай бол 32000 төгрөг, 2.3 метрээс дээш урттай нь 48000 төгрөг, хонины нэхий 6500 төгрөг, ямааны арьс 25000 төгрөгийн ханштай байлаа.


Хүснэгт 5. Арьс ширний дундаж үнэ, төгрөгөөр

	2013 оны 2-р сар	2014 он	
		1-р сар	2-р сар
Тэмээний шир	18000	27000	20500
Адууны шир	43000	35000	30500
Үхрийн шир	43000	52000	48000
Хонины арьс	9000	8500	6500
Ямааны арьс	22000	28000	25000
Ямааны ноолуур	52000	67000	67000

Зураг 8. Ямааны ноолуурын дундаж үнэ, төгрөгөөр



Зураг 9. Шатахууны үнэ, 2013 оны 12-р сар, 2014 оны 1, 2-р сарын байдлаар, төгрөг




Хүснэгт 6. Түлшний үнэ, 2014.02.26 төгрөг

Байршил	Түлшний мод (6-7 кг)=1 шуудай		Нүүрс (Налайх) (10-12 кг)
	Хар мод	Нарс	
Чингэлтэй	1800	1600	2600
Сүхбаатар	1600	1500	2500
Баянгол	1900	1600	
Цайз зах	1600	1400	2400
Хангай зах	1600	1500	2500
Дундаж үнэ	1700	1520	2500

Хүснэгт 7. Нэг литр шатахууны үнэ, 2014.02.26, төгрөг

ШТС	Аи 95	Аи 80	Аи 92	Мон 93	Дизель түлш	Газ
Жаст Ойл	1940	1580	1710		1840	
Петровис	1890	1550	1660	1660	1790	
Магнай трейд	1890	1550	1660		1790	
Сод монгол	1890	1550	1660		1790	
Шунхлай		1550	1660		1790	
Юнигаз						1290
Дундаж үнэ	1903	1556	1670	1660	1800	1290

Зураг 10. Төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш, 2011-2014 он



Мэдээллийн эх сурвалж: Монголбанкны статистикийн мэдээлэл

Хүснэгт 8. Хүнсний барааны дундаж үнэ, 2014 оны 2-р сарын 28-ны өдрийн байдлаар, ажиглалт хийсэн байршлаар /төгрөг/

		хэмжих нэгж	"Баянзүрх" зах	"Замбала" Супер- маркет	"Хүчит шонхор" зах	"Бөмбөгөр" ХТ	"Меркури" зах	"Барс" ХТ	"Таван эрдэнэ" зах	"Хархорин" зах	"Номин" Супер- маркет	"Макс" Супер- маркет	"Оргил" Супер- маркет	дундаж үнэ
"Алтан тариа" гурил	дээд	кг	1100	1152	1100	1000		1050	1100	1100	1137	1222	1078	1105
	1-р зэрэг	кг	750	745	750	700		750	850	800		817	748	770
"Алтан тариа" савласан гурил	дээдийн дээд	кг	1500	1590		1600	1800	1500	1700		1769	1830		1660
	дээд	кг	1100	1150	1100	1050	1300	1100	1200	1200	1179	1230	1110	1155
	1-р зэрэг	кг	750	840	750	700	900	750	850	800	829	840	780	800
	2-р зэрэг	кг	600	630	550	550	800	500	550	600		630	580	600
"Алейка" дээд гурил		кг	1400	1188	1400	1100	1500	1200	1350	1400		1306	1109	1295
Сүү	Сүү ХК 1л	литр	2200	2270	2200	2200	2400	2200	2300	2250	2229	2270	2220	2250
	Сүү ХК 0.5л	литр	950	950	900	900	1100	900	1000	950		900	940	950
	Задгай	литр			1500				1600	1500				1535
Тараг, Цөцгийтэй		литр	2100	2100	2100	2100	2300	2000	2100	2200	2399	2160	2100	2150
Талх	Атар	ширхэг	850	850	850	800	900	800	850	800	809	850	830	835
	Зууван чех	ширхэг	900	950	900	830	1100	900	950	830	939	950	850	920
Будаа	цагаан	кг	2300		2200	2200		2200	2500	2200	2799	2390		2350
	шар	кг	1500		1500	1500		1500	1600	1500		1920		1575
Цөцгийн тос, "Сүү" ХК		кг	2300		2200	2300	3000	2300	2200	2000		2050		2295
Ургамлын тос		1 литр	3000	3080	2900	3000	3300	3000	3300	3000	3259	3450	3160	3130
Ногоон цай, Гүрж		кг	4200	4320	4800	4600		4500	4500	4600		4820		4545
Элсэн чихэр		кг	1600		1500	1500	1900	1500	1600	1700		1900		1650

Хүснэгт 8-ын үргэлжлэл:

		хэмжих нэгж	"Баянзүрх" зах	"Замбала" Супер- маркет	"Хүчит шонхор" зах	"Бөмбөгөр" ХТ	"Меркури" зах	"Барс" ХТ	"Таван эрдэнэ" зах	"Хархорин" зах	"Номин" Супер- маркет	"Макс" Супер- маркет	"Оргил" Супер- маркет	дундаж үнэ
Хонины мах	ястай*	кг	6400		6500	8000	9500	7000	9000	6500	7899	6400		6700
	цул	кг	7400		7500					7500		7300		7425
Үхрийн мах	ястай*	кг	7800		7500	9000	9500	8500	9000	7800	8799	7600		7790
	цул*	кг	9000		9000	9800	11500	9500	11500	9500		9400		9640
Адууны мах, ястай*		кг	6000		6500	7000				6500				6475
Ямааны мах, ястай*		кг	5500		5500	6000				5700				5560
Төмс, монгол		кг	900	1200	900	1000	1200	800	1000	800	929	900	900	955
Лууван, монгол		кг	1200	1200	1300	1500	1800	1200	1500	1400	1499	1200	1200	1365
Байцаа, монгол		кг	1200	1200	1200	1200	1500	1200	1500	1200	1249	1200	1500	1285
Манжин, монгол		кг	1500	1800	1500	1500	2000	1200	1500	1500	1889	1500	1500	1580
Сонгино, хятад бөөрөнхий		кг	1200	1300	1200	1300	1500	1200	1500	1200	1249	1400	1500	1325
Алим, фүжи		кг	3500	4500	3500	3000	3500	3000	4000	3500	4699	4900	4800	3900
Өндөг, ОХУ		ширхэг	380	440	380	380	450	380	400	380	430	450	400	405

Тайлбар: * Махны дундаж үнийг хүнсний захуудын махны борлуулалтын хувийн жинд үндэслэн жигнэсэн дундаж аргаар тооцов.

Хүснэгт 9. Барилгын материалын үнэ, жил бүрийн 2-р сарын байдлаар /төгрөг/


Материалын нэр төрөл	Хэмжих нэгж	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он
Монгол улсад үйлдвэрлэсэн								
Хөнгөн бетон 700	м³	63000	67000	83000	95480	115000	150700	137500
Улаан тоосго М-100	мян.ш	120000	180000		120000	190000	297000	242000
Вакуум цонх (15х15)	м²	90000	80000	80000	80000	80000	90000	90000
Шалны банз /хувилгүй/	м³	71000	120000	120000	140000	150000	180000	240000
Захалсан банз /урт/ 25 мм	м³	16000	25000	23000	35000	38000	38000	40000
Палк (15х15, 3-3.5 м урттай)	ш	9500	15000	13000	20000	25000	28000	28000
ОХУ-д үйлдвэрлэсэн								
Хар цаас /чулуутай/	боодол	11500	14000	14000	14500	20000	18000	22000
Олиф	кг	2000	2000	1800	4600	3500	3500	2000
БНСУ-д үйлдвэрлэсэн								
Ханын цаас	боодол	4000	4300	4500	4500	5500	5500	6800
БНХАУ-д үйлдвэрлэсэн								
Цонхны шил 5мм	м²	8500	12000	12000	12000	15000	13000	12000
Хар цаас	боодол	4800	6000	7000	7000	9000	9700	11000
Хадаас 100мм	кг	1300	1800	2500	2500	2500	2700	2500
Тосон будаг	кг	1100	1500	2000	2000	2000	2500	2900
Эмульс /гадна/	5 кг	1800	2250					
	18 кг				18000	18000	18000	18000
Эмульс/дотор/	5кг	3500	1800					
	18 кг			6500	6500	6500	7000	8000
Плита 30х30 /шалны/	ш	450	600	750	800	850	850	1500
Шаазан угаагуур	ш	35000	42000	45000	55000	60000	80000	95000
Шаазан суултуур	ш	50000	60000	65000	80000	90000	100000	132000
Өдрийн гэрэл /суурьгүй/	ш	1000	1200	1800	1800	2000	2400	1500
Хаалга (бүргэд) /5мм/	ш	120000	130000	130000	135000	138000	160000	180000
Крант/Јотоо/	ш	12000	12000	25000	40000	45000	50000	72500
Уян душ /SHIDA/	ш	5500	15000	15000	15000	18000	25000	41000
Паркетан шал	м²	7500	8500	9000	10000	12000	13000	14000
Дүүжин тааз /60х60/	м²	2500	2800	3800	4000	3500	3500	5500



АЖ ҮЙЛДВЭР


Нийслэлийн аж үйлдвэрийн газрууд 2014 оны эхний 2 сард 678.9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 614.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад үйлдвэрлэлт 37.9 хувиар, борлуулалт 13.7 хувиар тус тус өссөн байна.

Зураг 11. АҮ-ийн 2013-2014 оны үйлдвэрлэлт, борлуулалт, тэрбум төгрөг




Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өнгөрсөн онтой харьцуулахад уул уурхайн олборлох салбарын үйлдвэрлэлт 86.2 хувиар, цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэл 22.0 хувиар тус тус өссөн байна.

Зураг 12. Үйлдвэрлэлт, 2012-2014 он, тэрбум төгрөг



Зураг 13. Борлуулалт, 2012-2014 он, тэрбум төгрөг



Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 308.5 тэрбум төгрөгийг дотоодод, 305.8 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна. 2014 оны эхний 2 сард нийт борлуулсан бүтээгдэхүүний 49.8 хувийг экспортоор гаргасан байна.

Нийт экспортын 21.8 хувийг төмрийн хүдэр олборлолт, 0.7 хувийг бусад ашигт малтмал олборлолт, 3.9 хувийг нүүрс олборлолт, 55.8 хувийг газрын тос шатдаг хий олборлолт, 3.6 хувийг нэхмэлийн үйлдвэрлэлт, 0.1 хувийг хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, 0.3 хувийг арьс шир боловсруулах үйлдвэрлэлт, 0.1 хувийг мебель тавилга үйлдвэрлэлт, 13.7 хувийг бусад үйлдвэрлэлт тус тус эзэлж байна.

Хүснэгт 10. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, салбараар, өссөн дүнгээр /оны үнээр, сая төгрөг/


Салбараар	Нийт бүтээгдэхүүн		
	2013 он II сар	2014 он II сар	$\frac{2014}{2013}$ %
Уул уурхай олборлох үйлдвэр	222396.9	414165.8	186.2
Нүүрс олборлолт	66357.7	33664.5	50.7
Газрын тос, шатдаг хий олборлолт	86907.5	171084.7	196.9
Төмрийн хүдэр олборлолт	61807.8	206600.0	3.3*
Бусад ашигт малтмал олборлолт	7323.9	2816.6	38.5
Боловсруулах үйлдвэр	183954.9	159677.9	86.8
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	83014.9	82494.9	99.4
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	8261.4	7456.9	90.3
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6966.4	7508.9	107.8
Үр тарианы гурил, малын тэжээл	8689.7	12160.8	139.9
Хүнсний бусад бүтээгдэхүүн	11693.7	10301.3	88.1
Ундаа үйлдвэрлэл	47403.7	45067.0	95.1
Тамхи үйлдвэрлэл	5834.9	4868.8	83.4
Нэхмэлийн үйлдвэрлэлт	19747.7	23620.6	119.6
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	899.9	1634.7	181.7
Арьс шир боловсруулах үйлдвэр	644.3	1865.0	2.9*
Мод модон эдлэл үйлдвэрлэл	1662.6	602.6	36.2
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1531.3	1147.1	74.9
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	3068.2	3311.2	107.9
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6481.9	7036.4	108.6
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	1259.6	2473.3	196.4
Төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл	1349.4	1874.5	138.9
Цахилгаан машин, хэрэгсэл үйлдвэрлэл	4.0	0.0	0.0
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	17.9	20.8	116.2
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	389.0	390.0	100.3
Мебель тавилга үйлдвэрлэл	392.8	1060.1	2.7*
Бусад үйлдвэрлэл	57656.5	27277.9	47.3
Цахилгаан, дулаан, усан хангамж	86139.4	105104.1	122.0
Цахилгаан, дулаан уур үйлдвэрлэлт	81682.8	100474.2	123.0
Ус ариутгал, усан хангамж	4456.6	4629.9	103.9
ДҮН	492491.2	678947.8	137.9

*дахин


Хүснэгт 11. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, салбараар, өссөн дүнгээр /оны үнээр, сая төгрөг/

Салбараар	Аж үйлдвэрийн борлуулалт			
	2013 он II сар	2014 он II сар	$\frac{2014}{2013} \%$	үүнээс: экспорт, %
Уул уурхай олборлох үйлдвэр	188998.2	315185.1	166.8	79.8
Нүүрс олборлолт	39086.9	29885.4	76.5	39.9
Газрын тос, шатдаг хий олборлолт	80253.2	170734.4	2.1*	100.0
Төмрийн хүдэр олборлолт	66944.5	111997.4	167.3	59.6
Бусад ашигт малтмал олборлолт	2713.6	2567.9	94.6	84.6
Боловсруулах үйлдвэр	265177.1	193986.5	73.2	28.0
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	92174.3	97862.2	106.2	0.2
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	9560.9	7342.6	76.8	0.9
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	7071.1	7737.0	109.4	
Үр тарианы гурил, малын тэжээл	6136.1	11405.1	185.9	
Хүнсний бусад бүтээгдэхүүн	11856.6	11153.6	94.1	
Ундаа үйлдвэрлэл	57549.6	60223.9	104.6	0.3
Тамхи үйлдвэрлэл	9201.7	10900.0	118.5	
Нэхмэлийн үйлдвэрлэлт	17502.2	22928.3	131.0	48.6
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	1066.3	672.6	63.1	
Арьс шир боловсруулах үйлдвэр	467.4	2201.9	4.7*	44.0
Мод модон эдлэл үйлдвэрлэл	1779.6	473.7	26.6	
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1528.5	1139.4	74.5	
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	3460.9	3168.5	91.6	
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	7005.0	7182.3	102.5	
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	987.7	1664.4	168.5	
Төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл	1113.2	1900.1	170.7	
Цахилгаан машин, хэрэгсэл үйлдвэрлэл	203.0	0.0	0.0	
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	17.9	20.8	116.2	
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	351.4	370.0	105.3	
Мебель тавилга үйлдвэрлэл	383.0	1061.5	2.8*	1.2
Бусад үйлдвэрлэл	127935.0	42440.8	33.2	98.7
Цахилгаан, дулаан, усан хангамж	86139.4	105104.1	122.0	
Цахилгаан, дулаан уур үйлдвэрлэлт	81682.8	100474.2	123.0	
Ус ариутгал, усан хангамж	4456.6	4629.9	103.9	
ДҮН	540314.7	614275.7	113.7	49.8

Зураг 14. Махны үйлдвэрлэлт, мян.тн




Зураг 15. Гурил үйлдвэрлэлт, мян.тн



Зураг 16. Талх, архи дарсны үйлдвэрлэлт



Зураг 17. Нүүрс олборлолт, мян.тн



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн яамны захиргааны статистикийн мэдээгээр дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо нийслэл хотод 2014 оны 2 дугаар сарын эцэст 11752 болж, өмнөх оны мөн үеэс 11.1 хувь буюу 1461 хүнээр буурчээ. Нийт ажилгүйчүүдийн 6067 буюу 51.6 хувь нь эмэгтэйчүүд байна.

Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 30.7 хувь буюу 3606 нь 15-24 насны, 35.0 хувь буюу 4113 нь 25-34 насны, 17.7 хувь буюу 2086 нь 35-44 насны, 16.6 хувь буюу 1947 нь 45-аас дээш насны хүмүүс байна.

2014 оны эхний 2 сард 4581 хүн дүүргийн хөдөлмөрийн хэлтэст ажилд орохоор шинээр бүртгүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 10.5 хувь буюу 436 хүнээр өсчээ.

2014 оны эхний 2 сард 840 хүн хөдөлмөрийн хэлтсээр зуучлуулан ажилд орсны 2.6 хувь нь улсын үйлдвэрийн газарт, 4.8 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 92.6 хувь нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад газарт ажилд оржээ.

2014 оны 2-р сард ажилгүй 2213 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 454 иргэн ажилд зуучлагдан орж, 1767 иргэн бүртгэлээс хасагджээ.

Хүснэгт 12. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр /3-р сарын 1-ний байдлаар/

	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2012 он	2013 он	2014 он	2012 он	2013 он	2014 он
Нийт ажилгүйчүүд	29309	13213	11752	100	100	100
Үүнээс : дээд боловсролтой	6739	4432	4613	23.0	33.6	39.3
Тусгай дунд боловсролтой	2469	1008	1094	8.4	7.6	9.3
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	2002	1024	685	6.8	7.7	5.8
Ерөнхий боловсролтой	17879	6685	5308	61.0	50.6	45.2
Мэргэжилгүй	220	64	52	0.8	0.5	0.4

Зураг 18. Дүүргийн ажилгүйчүүд, УБ хотын дүнд эзлэх хувь



Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 22.2 хувь буюу 2607 нь Баянзүрх, 19.3 хувь буюу 2274 нь Сонгинохайрхан, 15.3 хувь буюу 1802 нь Баянгол, 12.8 хувь буюу 1494 нь Чингэлтэй, 11.3 хувь буюу 1323 нь Сүхбаатар, 9.4 хувь буюу 1111 нь Хан-Уул, 6.8 хувь буюу 800 нь Налайх, 2.3 хувь буюу 272 нь Багануур, 0.6 хувь буюу 69 нь Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.



НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ


Нийслэлийн төсвийн орлого 2014 оны эхний 2 сард 116.4 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 2.9 тэрбум төгрөгөөр буюу 2.5 хувиар дутуу бүрдсэн байна. Төсвийн нийт орлогын 56.6 хувийг урсгал орлого (албан татвар, өмчийн татвар, дотоодын бараа үйлчилгээний татвар, бусад татвар хураамж, татварын бус орлого) 43.4 хувийг тусламжийн орлого эзэлж байна.

Нийт урсгал орлого 65.9 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 2.2 тэрбум төгрөгөөр буюу 3.2 хувиар, тусламжийн орлого 50.5 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 0.7 тэрбум төгрөгөөр буюу 1.5 хувиар тус тус дутуу бүрджээ.

Татварын орлого 59.9 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 0.9 тэрбум төгрөгөөр буюу 1.6 хувиар илүү бүрдсэн бол, татварын бус орлого 5.9 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 3.1 тэрбум төгрөгөөр буюу 34.4 хувиар дутуу бүрдсэн байна.

Хүн амын орлогын албан татвар төлөвлөснөөс 5.3 тэрбум төгрөгөөр илүү бүрдсэн бол өмчийн татвар төлөвлөснөөс 0.2 тэрбум төгрөгөөр, бараа үйлчилгээний албан татвар төлөвлөснөөс 0.4 тэрбум төгрөгөөр, бусад татвар, хураамж, төлбөр төлөвлөснөөс 3.9 тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрджээ.

Зураг 19. Төсвийн орлого, сая төгрөг



Хүснэгт 13. Нийслэлийн төсвийн орлого, дүүргээр, сая төгрөг

	Төсвийн орлого			Үүнээс:					
	Бүгд	ТБ %	Зөрүү	Татварын орлого			Татварын бус орлого		
				Бүгд	ТБ %	Зөрүү	Бүгд	ТБ %	Зөрүү
Багануур	2332.8	-	2332.8	68.8	-	68.8	269.4	-	269.4
Багахангай	652.0	82.4	-139.1	6.0	74.3	-2.1	10.1	211.3	5.3
Баянгол	9745.7	95.6	-447.6	1676.3	74.4	-578.0	351.9	45.3	-425.1
Баянзүрх	12000.4	98.8	-146.0	2146.1	109.3	182.0	466.9	57.0	-352.1
Налайх	2588.9	98.7	-34.3	82.4	79.9	-20.7	20.9	12.6	-144.7
Сонгинохайрхан	10974.8	99.2	-90.4	821.7	127.4	176.8	200.2	81.8	-44.7
Сүхбаатар	9799.8	102.8	263.5	3869.2	-	3869.2	384.5	20.9	-1458.8
Хан-Уул	7596.9	102.5	184.4	2648.6	89.1	-331.7	273.9	89.4	-32.5
Чингэлтэй	8818.9	106.0	501.4	2670.4	95.4	-128.9	1232.7	324.8	853.0
Нийслэлийн шууд	51928.2	90.6	-5360.2	45957.3	95.2	-2306.9	2732.2	60.4	-1787.9
Дүн	116438.4	97.5	-2935.5	59946.8	101.6	928.5	5942.7	65.6	-3118.1

Хүснэгт 14. Нийслэлийн төсвийн орлого, 2014 оны эхний 2 сард, сая төгрөг

Татварын орлогын нэр,төрөл	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	ТБ %	Зөрүү, сая.төг
Төсвийн орлогын дүн	119373.9	116438.4	97.5	-2935.5
Урсгал орлого	68079.1	65889.5	96.8	-2189.6
1. Татварын орлогын дүн	59018.3	59946.8	101.6	928.5
Хүн амын орлогын албан татвар	43683.2	49030.1	112.2	5346.9
Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын	39566.2	40664.3	102.8	1098.1
Үйл ажиллагааны орлогын	701.0	3438.6	490.5	2737.6
Хөрөнгө борлуулсны орлогын	1973.5	2069.2	104.8	95.7
Орлогыг тодорхойлох боломжгүй иргэний	827.2	218.1	26.4	-609.1
Бусад	615.3	2639.9	429.0	2024.6
Өмчийн татвар	2365.7	2213.8	93.6	-151.9
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	2359.6	2206.3	93.5	-153.3
Бууны албан татвар	6.1	7.5	123.0	1.4
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	852.8	483.5	56.7	-369.3
Авто тээврийн ба өөрөө явагч хэрэгслийн	852.8	483.5	56.7	-369.3
Бусад татвар, хураамж, төлбөр	12116.6	8219.4	67.8	-3897.2
Улсын тэмдэгтийн хураамж	4330.6	3242.1	74.9	-1088.5
Газрын төлбөр	5970.0	3265.3	54.7	-2704.7
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	35.6	8.7	24.4	-26.9
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1452.7	1414.7	97.4	-38.0
Усны төлбөр	292.2	268.5	91.9	-23.7
Ойгоос хэрэглээний мод, түлээ ашигласны	11.0	6.1	55.5	-4.9
Бусад татвар, хураамж	24.5	14.0	57.1	-10.5
2. Татварын бус орлогын дүн	9060.8	5942.7	65.6	-3118.1
Хувьцааны ногдол ашиг	43.0	5.6	13.0	-37.4
Хүү, торгуулийн орлого	3023.7	4283.9	141.7	1260.2
Түрээсийн орлого	110.0	71.0	64.5	-39.0
Төсөвт байгууллагын өөрийн орлого	5294.5	1283.4	24.2	-4011.1
Өмч хувьчлалын орлого	100.0	0.0	0.0	-100.0
Бусад нэр заагдаагүй орлого	489.6	298.8	61.0	-190.8
3. Хөрөнгийн орлого	0.0	13.0	-	13.0
Хөрөнгө худалдсаны орлого	0.0	13.0	-	13.0
4. Тусламжийн орлого	51294.8	50535.9	98.5	-758.9
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	46328.0	46349.0	100.0	21.0
ОНХНС*-гийн шилжүүлгийн орлого	3529.9	298.7	8.5	-3231.2
Аймаг нийслэлийн санхүүгийн дэмжлэг	1436.9	1926.7	134.1	489.8
Сум дүүргээс авсан тэгшитгэл	0.0	1961.5	-	1961.5


* - Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан

Зураг 20. Төсвийн орлого, зарлага, сая төгрөг



2014 оны эхний 2 сард орон нутгийн төсөв болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсвөөс төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 46.9 хувийг буюу 72.1 тэрбум төгрөгийн зардлыг санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 53.1 хувийг буюу 81.6 тэрбум төгрөгийг төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

Зураг 21. Нийслэлийн төсвийн зарлага, сая төгрөг



Төсвийн нийт зарлагын 34.7 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 3.8 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 37.4 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал болон бусад зардал, 18.5 хувийг нийгмийн халамжийн үйлчилгээ, 5.6 хувийг хөрөнгө оруулалт, их засварын зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт 15. Нийслэлийн төсвийн зарлага, сая төгрөг

	Орлогын дүн	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	зөрүү	
Багануур	2332.8	-	1631.4	-	1631.4	701.4
Багахангай	652.0	791.1	521.9	66.0	-269.2	130.1
Баянгол	9745.7	10193.3	7758.2	76.1	-2435.1	1987.5
Баянзүрх	12000.4	12146.5	8617.8	70.9	-3528.7	3382.6
Налайх	2588.9	2623.2	2142.0	81.7	-481.2	446.9
Сонгинохайрхан	10974.8	11065.2	8145.0	73.6	-2920.2	2829.8
Сүхбаатар	9799.8	9536.1	5845.2	61.3	-3690.9	3954.6
Хан-Уул	7596.9	7412.4	4726.3	63.8	-2686.1	2870.6
Чингэлтэй	8818.9	8776.1	5717.2	65.1	-3058.9	3101.7
Нийслэлийн шууд	51928.2	91151.7	26976.3	29.6	-64175.4	24951.9
Нийт дүн	116438.4	153695.6	72081.3	46.9	-81614.3	44357.1

Хүснэгт 16. Өглөгтэй дүүргүүд, сая төгрөг

	Сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн	Тухайн сард төлөгд- сөн	2-р сарын эцсийн үлдэгдэл
Багануур	83.8	25.4	0.0	109.2
Багахангай	8.0	6.3	0.0	14.3
Баянгол	30.6	19.1	0.0	49.7
Баянзүрх	25.9	25.4	0.0	51.3
Налайх	301.3	12.3	0.0	313.6
Сонгинохайрхан	694.5	33.7	0.0	728.2
Сүхбаатар	223.3	0.0	69.0	154.3
Чингэлтэй	38.4	26.5	0.0	64.9
Хан-Уул	247.9	22.9	0.0	270.8
Нийслэлийн шууд	16.7	3.5	0.0	20.2
Нийт	1670.4	175.1	69.0	1776.5

Нийслэлийн төсөв болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсвөөс санхүүждэг байгууллагууд сарын эхэнд 1.7 тэрбум төгрөгийн өглөгтэй байснаас тайлант хугацаанд шинээр 175.1 сая төгрөгийн өглөг үүсч, тухайн сард 69.0 сая төгрөгийн өглөгийг төлж барагдуулан, сарын эцэст 1.8 тэрбум төгрөгийн өглөгтэй үлдсэн байна.

Хүснэгт 17. Авлагатай дүүргүүд, сая.төгрөг

	Сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн	Тухайн сард бараг- дуулсан	2-р сарын эцсийн үлдэгдэл
Багануур	55.3	0.0	43.4	11.9
Багахангай	1.2	0.0	0.0	1.2
Баянгол	31.4	7.7	0.0	39.1
Баянзүрх	14.3	4.0	0.0	18.3
Сонгинохайрхан	5.5	0.0	0.2	5.3
Сүхбаатар	21.6	0.1	0.0	21.7
Чингэлтэй	7.1	4.7	0.0	11.8
Нийслэлийн шууд	280.7	12.2	0.0	292.9
Нийт	417.1	28.7	43.6	402.2

Төсөвт байгууллагууд энэ сард 28.7 сая төгрөгийн авлага шинээр үүсгэж, 43.6 сая төгрөгийн авлагыг барагдуулан сарын эцэст 402.2 сая төгрөгийн авлагатай үлджээ.




НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2014 оны эхний 2 сард нийслэлийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 17.3 мянган байгууллагын 357.8 мянга гаруй хүн хамрагдаж шимтгэл төлсөн ба тэдгээрийн 252.9 мянга буюу 70.7 хувь нь аж ахуйн нэгж байгууллагын, 78.5 мянга буюу 21.9 хувь нь төсөвт байгууллагын, 26.3 мянга буюу 7.4 хувь нь сайн дурын даатгуулагчид байна.

Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 16.7 хувиар буюу 51.1 мянган хүнээр нэмэгджээ.


Зураг 22. Даатгалын сангийн орлого, сая төгрөг



Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагууд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 87.3 хувиар биелүүлж, даатгалын санд нийт 97.6 тэрбум төгрөг хуримтлуулсан байна.

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 63.6 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 19.3 хувь нь эрүүл мэндийн даатгалын санд, 7.1 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 8.2 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 1.8 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

Зураг 23. Даатгалын сангийн зарлага



Нийслэлийн нийгмийн даатгалын сангаас эхний 2 сард даатгуулагч, иргэдэд 116.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сургалтын болон эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгосон байна.

Нийт зардлын 72.6 хувийг тэтгэврийн, 13.0 хувийг эрүүл мэндийн, 5.9 хувийг ҮОМШӨ-ний, 6.3 хувийг тэтгэмжийн, 2.2 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо 2-р сард 128.4 мянга, олгосон тэтгэврийн хэмжээ өссөн дүнгээр 68.3 тэрбум төгрөгт хүрчээ.

Олгосон нийт тэтгэврийн 73.2 хувийг өндөр насны, 9.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.0 хувийг тэжээгчээ алдсаны, 13.0 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2014 оны эхний 2 сард 6326 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 247 хүүхдээр олон байна.

Нийт төрсөн хүүхдийн 14.0 хувь буюу 883 нь бусад аймгийн харъяат эхчүүдээс төрсөн байна.

Хүснэгт 18. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл

	2012 он	2013 он	2014 он	$\frac{2014}{2013} \%$
Амаржсан эхийн тоо	5382	6045	6273	103.8
Амьд төрсөн хүүхэд	5406	6079	6326	104.1
Эхийн эндэгдэл	4	2	3	150.0
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	78	86	102	118.6
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	14.13	14.14	16.12	114.0

Нялхсын эндэгдлийн 26.8 хувь буюу 22 нь Баянзүрх, 17.1 хувь буюу 14 нь Сонгинохайрхан, 17.1 хувь буюу 14 нь Хан-Уул, 12.2 хувь буюу 10 нь Чингэлтэй, 11.0 хувь буюу 9 нь Баянгол, 7.3 хувь буюу 6 нь Сүхбаатар, 4.9 хувь буюу 4 нь Налайх, 2.4 хувь буюу 2 нь Багануур, 1.2 хувь буюу 1 нь Багахангай дүүрэгт тус тус гарсан байна.

Нялхсын эндэгдлийн 18.6 хувь буюу 19 нь бусад аймгийн харъяат байна. Өмнөх оны мөн үеэс нялхсын эндэгдэл 1.98 промилээр өсчээ.

Нийслэлд 2014 оны эхний 2 сард 2470 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 12.6 хувь буюу 357 хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 3.42 продицимилээр тус тус буурчээ.

Зураг 24. Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 22.8 хувийг тэмбүү, 19.5 хувийг салхинцэцэг, 15.3 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 11.5 хувийг трихомониаз, 10.3 хувийг заг хүйтэн, 5.1 хувийг цусан суулга, 4.2 хувийг гар хөл амны өвчин, 3.4 хувийг вируст гепатит өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж

Хүснэгт 19. Нийслэлд гарсан халдварт өвчин, эхний 2 сард

	хэмжих нэгж	2013 он	2014 он	өсөлт, бууралт	
				тоо/пункт	Хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн, үүнээс	бодит тоо	2827	2470	- 357	- 12.6
	10000 хүнд	23.23	19.81	- 3.42	
Вируст хепатит	бодит тоо	280	84	- 196	- 3.3 дах
	10000 хүнд	2.30	0.67	- 1.63	
Менингит	бодит тоо	6	1	- 5	- 6.0 дах
	10000 хүнд	0.05	0.01	- 0.04	
Цусан суулга	бодит тоо	123	125	2	1.6
	10000 хүнд	1.01	1.00	- 0.01	
Салхин цэцэг	бодит тоо	462	482	20	4.3
	10000 хүнд	3.80	3.87	0.07	
Гахай хавдар	бодит тоо	361	36	- 325	- 10.0 дах
	10000 хүнд	2.97	0.29	- 2.68	
Сальмонеллөз	бодит тоо	2	3	1	1.5 дах
	10000 хүнд	0.02	0.03	0.01	
Улаан эсэргэнэ	бодит тоо	34	34	-	-
	10000 хүнд	0.28	0.27	- 0.01	
Хоолны хордлого	бодит тоо	9	21	12	2.3 дах
	10000 хүнд	0.07	0.17	0.10	
Ёлом	бодит тоо	14	11	- 3	- 21.4
	10000 хүнд	0.12	0.09	- 0.03	
Улаанууд	бодит тоо	1	-	- 1	-
	10000 хүнд	0.01	-	- 0.01	
Бруцеллөз	бодит тоо	2	2	-	-
	10000 хүнд	0.02	0.02	-	
Гар хөл амны өвчин	бодит тоо	22	103	81	4.7 дах
	10000 хүнд	0.18	0.83	0.65	
Тэмбүү	бодит тоо	544	564	20	3.7
	10000 хүнд	4.47	4.52	0.05	
Заг хүйтэн	бодит тоо	270	254	- 16	- 5.9
	10000 хүнд	2.22	2.04	- 0.18	
Трихомониаз	бодит тоо	299	284	- 15	- 5.0
	10000 хүнд	2.46	2.28	- 0.18	
Шинээр илэрсэн сүрьеэ	бодит тоо	349	378	29	8.3
	10000 хүнд	2.87	3.03	0.16	
ДОХ	бодит тоо	-	1	1	-
	10000 хүнд	-	0.01	0.01	



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж температур 2014 оны 2 сард дунджаар -18.4°C байв. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 1.0°C -аар дулаан, олон жилийн дундажтай харьцуулахад -1.7°C -аар хүйтэн байлаа. Энэ сард үнэмлэхүй их температур 2.1°C , үнэмлэхүй бага температур -29.5°C , хур тунадасны нийлбэр 1.9 мм, салхины үнэмлэхүй их хурд 12 м/секунд хүрсэн.


Хүснэгт 20. Агаарын бохирдолт, $\text{мг}/\text{м}^3$

Бодисын нэр	Стандарт хэмжээ	Хийсэн ажиглалтын тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдол /тоо/	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий / SO_2 /	0.020	182	0.147	160	0.049
Азотын давхар исэл / NO_2 /	0.040	170	0.120	118	0.051
Тоосжилт / PM_{10} /	0.100	135	0.653	119	0.259
Тоосжилт / $\text{PM}_{2.5}$ /	0.050	42	0.286	33	0.109
Нүүрстөрөгчийн дутуу исэл / CO /	1.5	400	8.250	-	1.918
Озон / O_3 /	0.100	233	0.097	-	0.025


Мэдээллийн эх үүсвэр: Ус, цаг уур орчны хүрээлэн

Агаар дахь бохирдуулагч бодисын агууламжийг нийслэл хотын нутаг дэвсгэрт 7 харуул цэгт хэмжихэд азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2014 оны 2-р сард Улаанбаатар хотын Баруун дөрвөн замын орчимд 27 удаа, 32-ын тойрог орчимд 23 удаа, 13-р хороолол, 1-р хороолол орчимд тус бүр 18 удаа, Хархорин захын орчимд 16 удаа, Офицеруудын ордон орчимд 14 удаа, Ургах наран хороолол орчимд 2 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж 32-ын тойрог орчимд 28 удаа, Баруун дөрвөн зам, 1-р хороолол орчимд тус бүр 24 удаа, Ургах наран хороолол орчимд 23 удаа, Офицеруудын ордон, Хархорин захын орчимд тус бүр 21 удаа, 13-р хороолол орчимд 19 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ.

Зураг 25. Хүхэрлэг хийн агууламж, $\text{мг}/\text{м}^3$




Зураг 26. Азотын давхар ислийн агууламж, мг/м³




Тоосны 10 микроноос бага хэмжээтэй агууламж 32-ын тойрог орчимд 28 удаа, Хархорин захын орчимд 26 удаа, Баруун дөрвөн замын орчимд 25 удаа, 13-р хороолол орчимд 23 удаа, Ургах наран хороолол орчимд 17 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж 13-р хороолол орчимд 18 удаа, Баруун дөрвөн замын орчимд 15 удаа стандартаас давсан байна.

Зураг 27. Тоосны /PM₁₀/ агууламж, мг/



Зураг 28. Нүүрстөрөгчийн дутуу исэл, мг/м³



Хүснэгт 21. Агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м³, 2-р сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Баруун дөрвөн зам	1-р хороолол	13-р хороолол	32-ын тойрог	Оффисуудын ордон	Хархорин зах	Ургах наран хороолол
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	0.042	0.073	0.047	0.065	0.056	0.031	0.032
	Хамгийн их	0.075	0.147	0.070	0.100	0.104	0.056	0.051
	XXX*-с давсан хувь	88.9	92.3	95.0	100.0	84.0	75.0	82.1
	Хэмжилтийн тоо	27	26	20	28	25	28	28
Азотын давхар исэл NO ₂	Дундаж	0.094	0.047	0.049	0.053	0.039	0.042	0.030
	Хамгийн их	0.120	0.074	0.082	0.069	0.071	0.063	0.043
	XXX*-с давсан хувь	100.0	72.0	78.3	88.5	56.0	57.1	12.5
	Хэмжилтийн тоо	27	25	23	26	25	28	16
Нүүрстөрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	3.593	-	1.604	2.412	-	1.179	0.804
	Хамгийн их	8.250	-	3.500	5.625	-	3.288	1.875
	XXX*-с давсан хувь	0.0	-	0.0	0.0	-	0.0	0.0
	Хэмжилтийн тоо	79	-	69	84	-	84	84
Тоос PM10	Дундаж	0.244	-	0.300	0.395	-	0.223	0.131
	Хамгийн их	0.414	-	0.617	0.636	-	0.653	0.652
	XXX*-с давсан хувь	92.6	-	95.8	100.0	-	92.9	60.7
	Хэмжилтийн тоо	27	-	24	28	-	28	28
Тоос PM2.5	Дундаж	0.139	-	0.079	-	-	-	-
	Хамгийн их	0.286	-	0.133	-	-	-	-
	XXX*-с давсан хувь	83.3	-	75.0	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	18	-	24	-	-	-	-
Озон O ₃ **	Дундаж	-	-	0.023	0.010	-	-	0.043
	Хамгийн их	-	-	0.097	0.039	-	-	0.093
	XXX*-с давсан хувь	-	-	0.0	0.0	-	-	0.0
	Хэмжилтийн тоо	-	-	65	84	-	-	84

*- Хүлцэх хэм хэмжээ, ** - CO, O₃ -ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон.

Туул голын усны найрлага Туул-Зайсан харуул цэгт ус хөлдсөн тул хэмжилт хийгдээгүй, Туул-Налайх харуул цэгт бохирдуулагч бодисын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнд, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд нитритийн нэгдлийн хэмжилт хийгдээгүй, хүчилтөрөгч маш бохирдолтой, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 25.5 дахин, амоны азот 32.2 дахин, эрдэс фосфор 8.6 дахин хүлцэх хэм хэмжээнээс хэтэрч, Туул голын ус маш бохирдолтой хэвээр байна.

Хүснэгт 22. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м³, 2-р сард

	Стандарт Хэмжээ	“Туул-Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
		хэмжээ	бодисын хэтрэлт	Хэмжээ	бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч (O ₂)	≥6	3.9	хэвийн	-	Хэмжих боломжгүй, маш бохир
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ ₅)	≤ 3	2.1	хэвийн	76.5	25.5 дахин
Нитритийн нэгдэл (NO ₂)	≤ 0.02	хэмжилт хийгдээгүй			
Амоны азот (NH ₄)	≤0.5	0.02	хэвийн	16.08	32.2 дахин
Эрдэс фосфор (P)	≤0.1	0.002	хэвийн	0.860	8.6 дахин

Мэдээллийн эх үүсвэр : Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори




ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Нийслэлийн хүн амд 2014 оны эхний 2 сард 5.6 сая м³, аж ахуйн нэгж, байгууллагад 2.0 сая м³ цэвэр усыг борлуулжээ. Хүн амд түгээсэн цэвэр усны 96.3 хувь буюу 5.4 сая м³-ыг нь төвлөрсөн шугамаар, 204.8 мян м³-ыг ус түгээх байраар, 1.7 мянган м³ усыг тээврээр түгээсэн байна.

Хүснэгт 23. Ус суваг ашиглалтын үйлчилгээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2013 он II сар	2014 он II сар	$\frac{2014}{2013} \%$
Шахсан ус	мян.м ³	9135.5	9021.4	98.8
Борлуулсан ус	мян.м ³	7344.6	7570.0	103.1
Хүн амд	мян.м ³	5492.4	5586.6	101.7
ААНБ-д	мян.м ³	1852.2	1983.4	107.1
Татан зайлуулсан бохир	мян.м ³	7315.6	7335.2	100.3
Хүн амаас	мян.м ³	5164.6	5132.9	99.4
ААНБ-аас	мян.м ³	2151.0	2202.3	102.4
Ус борлуулалтын орлого	сая төг	2581.9	2682.4	103.9
Хүн амаас	сая төг	1543.0	1566.8	101.5
ААНБ-аас	сая төг	1038.8	1115.6	107.4
Сувагжуулалтын орлого	сая төг	1474.7	1496.7	101.5
Хүн амаас	сая төг	760.5	756.2	99.4
ААНБ-аас	сая төг	714.2	740.5	103.7

Зураг 29. Борлуулсан ус, мян м³



2014 оны эхний 2 сард борлуулсан усны нийт хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 3.1 хувиар нэмэгдсэн байна.

Нийт борлуулсан усны 74.0 хувийг хүн амд борлуулсан ус, 26.0 хувийг аж ахуйн нэгж, байгууллагад борлуулсан ус эзэлж байна.

Зураг 30. Татан зайлуулсан бохир, мян м³



Цэвэрлэх байгууламжаар 9.2 сая м³ бохирыг цэвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн 7.3 сая м³ бохир шингэнийг татан зайлуулсан байна.



ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2014 оны эхний 2 сард нийт 83 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.4 хувиар буурчээ. Нийт гамшиг бүгд хүний үйл ажиллагаатай холбоотой осол байна. Тухайлбал, энэ оны эхний 2 сард хүний үйл ажиллагаатай холбоотой сум галт хэрэгслийн осол 1, бичил уурхай, нурангины осол 2, химийн бодисын осол 9, бусад осол 71 гарчээ.

Гамшгийн улмаас 2 хүн амь насаа алдсан байна. Гамшгаас 88 хүнийг аварч, гамшгийн уршгийг арилгах ажилд нийт 1.3 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 24. Хүний үйл ажиллагаатай холбоотой осол, төрлөөр

Ослын төрөл	2013 он	2014 он	$\frac{2014}{2013} \%$
Бүгд	82	83	101.2
Тэсэрч дэлбэрэх бодисын осол	2	0	0.0
Сум галт хэрэгслийн	0	1	-
Химийн бодисын	14	9	64.3
Бичил уурхай, нурангины	1	2	200.0
Үйлдвэрийн осол	1	0	0.0
Бусад	64	71	110.9

Нийслэл хотод 2014 оны эхний 2 сард ахуйн 644 гал түймэр гарав. Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилвал: цахилгаанаас 126, санамсаргүй байдлаас 455, санаатай үйлдлээр 4, шалтгаан тогтоогдоогүй 39, бусад шалтгаанаар 20 гал түймэр гарсан байна.

Гал түймэрт иргэний хувийн өмчийн 339, төрийн өмчийн 163, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 42 объект өртөж, нийт 1.4 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Зураг 31. Гал түймэр, шалтгаанаар



Зураг 32. Гал түймэр, байршлаар, хувиар



Гал түймэрт 456 гэр, орон сууц, 130 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 58 машин техник өртсөн байна. Гал түймрийн улмаас 18 хүн амь насаа алдаж, 5 хүн түлэгдэж гэмтжээ. Гал түймрийн аюулаас 248 хүн, 66 байшин барилга, 913.0 сая төгрөгийн эд хөрөнгийг аварсан байна.

Гал түймрийн 5 нь Багануур, 105 нь Баянгол, 158 нь Баянзүрх, 29 нь Налайх, 80 нь Сүхбаатар, 74 нь Хан-Уул, 64 нь Чингэлтэй, 129 нь Сонгинохайрхан дүүрэгт тус тус гарсан байна.

Нийслэлийн Онцгой байдлын газраас 2014 оны эхний 2 сард 17 барилгын зураг төсөл, ашиглалтанд хүлээн авч буй 37 барилгад хяналт тавьж ажиллажээ. Мөн 5025 айл өрх, 1787 объектод үзлэг шалгалт хийж, 8542 галын зөрчил илрүүлж, 44 байгууллагын үйл ажиллагааг зогсоож, байгууллага, албан тушаалтан, иргэнд 445 заавал биелүүлэх албан шаардлага, 487 мэдэгдэл хүргүүлж, 11.5 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.


Малын зүй бусын хорогдол

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2014 оны эхний 2 сард нийт 478 толгой том мал зүй бусаар хорогдсон байна.

Малын зүй бус хорогдлын 31.0 хувь буюу 148 толгой мал өвчнөөр хорогджээ.

Хорогдсон нийт малын 6.9 хувийг адуу, 20.5 хувийг үхэр, 33.3 хувийг хонь, 39.3 хувийг ямаа эзэлжээ.

Зураг 33. Малын зүй бус хорогдол, эхний 2 сард



Хүснэгт 25. Малын зүй бус хорогдол, дүүргээр, эхний 2 сард

Дүүрэг	2013 он	2014 он	үүнээс :			
			адуу	үхэр	хонь	ямаа
Багануур	493	237	24	25	83	105
Багахангай	16	18	-	2	6	10
Баянзүрх	20	85	5	12	36	32
Налайх	27	25	3	2	6	14
Сонгинохайрхан	139	63	-	31	19	13
Сүхбаатар	6	13	1	8	-	4
Хан-Уул	85	34	-	15	9	10
Чингэлтэй	-	3	-	3	-	-
Дүн	786	478	33	98	159	188



Нийслэл хотод 2014 оны эхний 2 сард 2673 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3.3 хувь буюу 86 хэргээр өсчээ. Гэмт хэргийн илрүүлэлт 50.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 10.1 пунктээр дээгүүр байна.

Гэмт хэргийн улмаас 866 хүн гэмтэж осолдсоноос 11.7 хувь буюу 101 хүн нас барж, төр ард иргэдэд 8908.7 сая төгрөгийн хохирол учруулсны 15.6 хувь буюу 1393.8 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Зураг 34. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Бүртгэгдсэн гэмт хэргийн 31.6 хувийг хулгайн, 26.2 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 8.8 хувийг танхайн, 7.6 хувийг залилан, 5.9 хувийг тээврийн хэрэгс-лийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 26. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, төрлөөр, эхний 2 сард

	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2013 он	2014 он	Тоо	Хувь
Хүний амь	22	15	- 7	- 31.8
Хүчин	25	33	8	32.0
Дээрэм	101	87	- 14	- 13.9
Хулгай	782	844	62	7.9
Булаалт	36	31	- 5	- 13.9
Залилан	190	203	13	6.8
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	589	701	112	19.0
Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	163	158	- 5	- 3.1
Бусдыг амиа хорлоход хүргэх	203	98	- 105	- 2.1 дах
Ашиглах	32	30	- 2	- 6.3
Танхайрах	227	236	9	4.0
Бусад	217	237	20	9.2
БҮГД	2587	2673	86	3.3

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 1845 болж, 2013 оны мөн үеэс 8.0 хувь буюу 136 хүнээр өссөн байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 13.5 хувь буюу 249 нь гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, 23.1 хувь буюу 427 нь согтуугаар үйлдсэн, 4.8 хувь буюу 88 нь урьд ямар нэг ял шийтгэл хүлээж байсан хүмүүс үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 4.5 хувь буюу 83 нь хүүхэд, 18.3 хувь буюу 337 нь эмэгтэйчүүд байна.

2014 оны эхний 2 сард 11251 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 4.1 хувь буюу 440 хүнээр өссөн байна.

Хүснэгт 27. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, дүүргээр, эхний 2 сард

дүүрэг	Нийт бүртгэсэн гэмт хэрэг		Гэмт хэргийн өсөлт, бууралт	
	2013 он	2014 он	Тоо	хувь
Багануур	45	48	3	6.7
Багахангай	5	2	- 3	- 2.5 дах
Баянгол	380	470	90	23.7
Баянзүрх	607	647	40	6.6
Налайх	42	52	10	23.8
Сонгинохайрхан	445	458	13	2.9
Сүхбаатар	469	411	- 58	- 12.4
Чингэлтэй	405	358	- 47	- 11.6
Хан-Уул	189	227	38	20.1
ДҮН	2587	2673	86	3.3

Хүснэгт 28. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр, 2014 оны эхний 2 сард


дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс сэжигтнийг илрүүлж ял сонгосон	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
Багануур	16	8	50.0
Багахангай	-	-	-
Баянгол	209	135	64.6
Баянзүрх	427	188	44.0
Налайх	14	6	42.9
Сонгинохайрхан	223	125	56.1
Сүхбаатар	174	72	41.4
Чингэлтэй	201	96	47.8
Хан-Уул	105	57	54.3
ДҮН	1369	687	50.2

Хүснэгт 29. Бүртгэгдсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр, эхний 2 сард

дүүрэг	Нийт хулгайн гэмт хэргийн тоо		Үүнээс: хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо	
	2013 он	2014 он	2013 он	2014 он
Багануур	10	11	7	10
Багахангай	-	1	-	-
Баянгол	97	126	77	107
Баянзүрх	203	256	147	228
Налайх	5	10	2	8
Сонгинохайрхан	147	145	127	135
Сүхбаатар	145	133	108	105
Чингэлтэй	128	109	98	104
Хан-Уул	47	53	34	47
ДҮН	782	844	600	744

2014 оны эхний 2 сард хүндэтгэр хэрэг 1267, хөнгөн хэрэг 1172 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 0.2-11.1 хувиар өсч, хүнд хэрэг хэрэг 191, онц хүнд 43 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 8.6-25.9 хувиар буурчээ.

Зураг 35. Гэмт хэргийн тоо, ангиллаар




НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР



<http://ubstat.mn>



Статистикийн ном, эмхэтгэл,
танилцуулга, сэтгүүлийг энэхүү
апп-ыг ашиглан унших боломжтой



www.1212.mn -ээс статистик мэдээллийг
интерактив байдлаар аваарай